

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн сахилгын хорооны 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/026/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч: Я.Самбууням
Утас: 329871 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Санхүү, нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn
Аудитор: Г.Оюунтөгөлдөр
Утас: 261740 Цахим хаяг: Oyuntuguldurg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ
ДАРГА Д.АРИУНТУЯА ТАНАА

2025.04.25 № 1605
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Шүүхийн сахилгын хорооны 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангууд, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант хугацаанд бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлаас үндсэн үйл ажиллагааны зардалд 89.8 сая төгрөгийг зарцуулснаас 62.3 сая төгрөг буюу 69.4 хувь нь судалгааны ажлын төлбөр байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 95 дугаар зүйлийн 95.17-д “Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд үйл ажиллагааны дүрэм, бүтэц, орон тоо, албан тушаалын цалингийн хэмжээг тус Сахилгын хорооны зөвлөгөөн батална” гэсэн нэмэлт өөрчлөлт 2024 оны 06 дугаар сард орсонтой холбоотойгоор тайлант оны төсвийг 678.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн, нийт 4,862.1 сая төгрөгөөр тодотгон баталсан байна.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д. ЗАГДЖАВ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	825,614.7	874,124.4
33	АВЛАГА	5,146.5	2,864.3
34	УРЬДЧИЛГАА	709,195.6	716,693.1
35	БАРАА МАТЕРИАЛ	111,272.6	154,567.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,121,495.9	1,195,074.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,121,495.9	1,195,074.9
39200	Биет хөрөнгө	1,112,384.9	1,188,333.9
39300	Биет бус хөрөнгө	9,111.0	6,741.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,947,110.7	2,069,199.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,990.1	10,650.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,990.1	10,650.0
41300	Өглөг	5,990.1	10,650.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,941,120.6	2,058,549.3
51	Засгийн газрын хувь оролцоо	1,941,120.6	2,058,549.3
51200	Хуримтлагдсан үр дүн	1,941,120.6	2,058,549.3
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,947,110.7	2,069,199.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,505,158.6	4,864,550.3
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,139.0	2,460.0
120	Нийтлэг татварын бус орлого	2,139.0	2,460.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,503,019.6	4,862,090.3
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,090,508.2	4,746,470.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,090,508.2	4,746,470.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,904,384.4	4,347,483.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,836,729.8	2,910,729.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,355.8	362,443.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,998.2	97,810.8
2104	Хангамж, бараа материалын зардал	207,185.2	259,743.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	37,425.3	52,591.6
2107	Томилолт, зочны зардал	61,999.9	119,676.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	77,651.7	200,914.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	314,038.5	343,573.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,123.8	398,987.0

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	414,650.4	118,080.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.0	651.4
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	414,650.4	117,428.7

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,503,019.6	4,862,090.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,503,019.6	4,862,090.3
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,246,240.3	4,538,923.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,246,240.3	4,538,923.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,060,116.5	4,139,936.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,836,938.6	2,913,799.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	231,147.0	362,238.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,998.2	94,453.8
2104	Хангамж, бараа материалын зардал	197,771.4	270,537.0
2105	Нормативт зардал	4,127.8	9,875.1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	390,067.9	74,638.9
2107	Томилолт, зочны зардал	61,999.9	119,176.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	151,665.7	199,036.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	48,400.0	96,182.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	186,123.8	398,987.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	256,779.3	323,167.0
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	256,779.3	323,167.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	256,779.3	323,167.0
2200	Дотоод эх үүсвэрээр	256,779.3	323,167.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(256,779.3)	(323,167.0)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-	-
IX	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
X	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,526,470.1	1,526,470.1
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,526,470.1	1,526,470.1
9	Тайлант үеийн үр дүн	414,650.4	414,650.4
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,941,120.6	1,941,120.6
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,941,120.6	1,941,120.6
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,941,120.6	1,941,120.6
19	Тайлант үеийн үр дүн	117,544.6	117,428.7
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,058,665.2	2,058,549.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,862,090,300.00	4,769,817,593.16	92,272,706.84	98.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,862,090,300.00	4,769,817,593.16	92,272,706.84	98.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,555,374,700.00	4,463,103,293.16	92,271,406.84	98.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,970,955,300.00	2,913,799,476.99	57,155,823.01	98.1
210101	Үндсэн цалин	1,851,033,100.00	1,697,314,118.55	153,718,981.45	91.7
210102	Нэмэгдэл	700,426,200.00	675,306,179.31	25,120,020.69	96.4
210103	Унаа хоолны хөнгөлөлт	254,732,300.00	287,499,874.85	(32,767,574.85)	112.9
210104	Урамшуулал	164,763,700.00	253,679,304.28	(88,915,604.28)	154.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	396,369,500.00	362,237,946.79	34,131,553.21	91.4
210201	Тэтгэврийн даатгал	269,531,100.00	246,553,688.64	22,977,411.36	91.5
210202	Тэтгэмжийн даатгал	31,709,700.00	29,342,428.33	2,367,271.67	92.5
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,854,800.00	15,141,766.41	713,033.59	95.5
210204	Ажилгүйдлийн даатгал	15,854,800.00	14,240,012.75	1,614,787.25	89.8
210205	Эрүүл мэндийн даатгал	63,419,100.00	56,960,050.66	6,459,049.34	89.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	94,708,000.00	94,453,847.68	254,152.32	99.7
210302	Түлш, халаалт	5,050,000.00	5,050,000.00	0.00	100.0
210304	Байрны түрээс	89,658,000.00	89,403,847.68	254,152.32	99.7
2104	Хангамж, бараа материалын зардал	271,218,500.00	270,536,950.70	681,549.30	99.8
210401	Бичиг хэрэг	45,833,200.00	45,833,198.00	2.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	81,906,800.00	81,906,800.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	51,274,800.00	50,593,252.70	681,547.30	98.7
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	420,000.00	0.00	100.0

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	91,783,700.00	91,783,700.00	0.00	100.0
2105	Нормативт зардал	9,875,100.00	9,875,100.00	0.00	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,875,100.00	9,875,100.00	0.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	392,340,800.00	392,305,895.00	34,905.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	157,540,800.00	157,511,200.00	29,600.00	100.0
210604	Урсгал засвар	234,800,000.00	234,794,695.00	5,305.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	119,176,000.00	119,176,000.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	119,176,000.00	119,176,000.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	204,549,400.00	204,535,976.00	13,424.00	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	89,752,000.00	89,752,000.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	45,000,500.00	44,995,190.00	5,310.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	906,900.00	906,899.00	1.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	453,500.00	446,887.00	6,613.00	98.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	68,436,500.00	68,435,000.00	1,500.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	96,182,100.00	96,182,100.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	96,182,100.00	96,182,100.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	306,715,600.00	306,714,300.00	1,300.00	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	306,715,600.00	306,714,300.00	1,300.00	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	22,074,300.00	22,074,300.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	284,641,300.00	284,640,000.00	1,300.00	100.0
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,862,090,300.00	4,769,817,593.16	92,272,706.84	98.1
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,862,090,300.00	4,769,817,593.16	92,272,706.84	98.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	4,862,090,300.00	4,769,817,593.16	92,272,706.84	98.1
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	55	54	1	98.2
620001	Удирдах ажилтан	13	13	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	23	22	1	95.7
620003	Үйлчлэх ажилтан	19	19	0	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	55	54	1	98.2
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	27	26	1	96.3
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	19	19	0	100.0

650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5	5	0	100.0
650012	Шүүгч, прокурор	4	4	0	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 722.5 сая төгрөгийн алдаа¹, 10.2 сая төгрөгийн зөрчлийг² илрүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 3 зөвлөмж хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

- *Тайлант оны урсгал зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг нийт 306.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан;*
- *Санхүүгийн байдлын тайланд 2023 оны үр дүнг 414.7 сая төгрөгөөр дутуу, 2022 оны үр дүнг 414.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан;*
- *Зам ашигласны төлбөр, хураамжийн 1.1 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн.*

Нийт илрүүлсэн зөрчлөөс 10.2 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй дүгнэлт” өглөө.

3.1. Зөвлөмж

1. Худалдан авалттай холбоотой

Илрүүлэлт 1. Ажлын албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаалыг үндэслэн Эйр Эко ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах №24/45 дугаар гэрээгээр хуралдааны өрөөнд байршуулах 15 ширхэг чийгшүүлэгчтэй агаар цэвэршүүлэгчийг 7.0 сая төгрөгөөр худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 14 дүгээр зүйлийн 14.2.3-д “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “үр ашигтай байх”, 4.2.3-т “хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, арга хэмжээ нь хамгийн бага зардлаар хамгийн өндөр үр дүнг хангахад чиглэсэн байх”, 4.2.7-д “аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Урсгал төсвөөс олон ширхэг үндсэн хөрөнгө бэлтгэсэн зөрчлийг арилгаж, давтан гаргахгүй байх, баталсан төсвийг үр ашигтай зарцуулах.

2. Авлагатай холбоотой

Илрүүлэлт 2. Албан хаагчдад олгосон цалин, хөлс түүнтэй адилтгах орлоготой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.5-т “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг

¹Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан хаагчдын цалин, хөлс түүнтэй адилтгах орлоготой холбоотой тооцооллыг сайжруулж, төсөвт байгууллага хооронд авлага, өглөг үүсгэхгүй байх

3. Өглөгтэй холбоотой

Илрүүлэлт 3. Байгууллагад өгөх өглөгийг 0.4 сая төгрөгөөр илүү тооцоо нийлж, баталгаажуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.4-т “үнэн зөв байх”, 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Авлага, өглөгийн үлдэгдлийг үнэн зөв тооцоо нийлж, баталгаажуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Аудитаар нийт 722.5 сая төгрөгийн 3 алдаа³ илрүүлж, аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл*/сая төгрөгөөр/*

№	Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс: Залруулсан	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны урсгал зардлын төлөвлөгөө болон гүйцэтгэлийг нийт 306.7 сая төгрөгөөр дутуу тайлагнасан байна.	1	306.7	1	306.7	1	306.7
2	Санхүүгийн байдлын тайланд 2023 оны үр дүнг 414.7 сая төгрөгөөр дутуу, 2022 оны үр дүнг 414.7 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	414.7	1	414.7	1	414.7
3	Зам ашигласны төлбөр, хураамжийн 1.1 сая төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардалд бүртгэсэн байна.	1	1.1	1	1.1	1	1.1
НИЙТ		3	722.5	3	722.5	3	722.5

4.2. Аудитаар нийт 10.2 сая төгрөгийн зөрчил⁴ илэрснээс зөрчлийг арилгах 3 зөвлөмжийг өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл*/сая төгрөгөөр/*

№	Зөрчлийн товч утга	Нийт		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ажлын албаны даргын 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/104 дүгээр тушаалаар байгууллагын хуралдааны өрөөнд байршуулах тоног төхөөрөмж худалдан авахаар Эйр Эко ХХК-тай байгуулсан худалдах, худалдан авах №24/45 дугаар гэрээгээр 15 ширхэг чийгшүүлэгчтэй агаар цэвэршүүлэгчийг 7.0 сая төгрөгөөр худалдан авч, төсвийг үр ашиггүй зарцуулсан байна.	1	7.0	1	7.0
2	Байгууллагад өгөх өглөгийг 0.4 сая төгрөгөөр илүү тооцоо нийлж, баталгаажуулсан байна.	1	0.3	1	0.3
3	Албан хаагчдад олгосон цалин, хөлс түүнтэй адилтгах орлоготой холбоотойгоор нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.	1	2.9	1	2.9
НИЙТ		3	10.2	3	10.2

4.3. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх, тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх хариуцлага тооцуулах 1 албан шаардлага, 5 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/сая төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой							
1	Шилэн дансны тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 6.4.5-д заасныг үндэслэн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг байршуулахаас орлогын 320.7 сая төгрөгийн 1 гүйлгээ, зарлагын 12.7 сая төгрөгийн 2 гүйлгээг мөнгөн журналаас зөрүүтэй мэдээлсэн, өмнөх онд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна.	1	-	1	-		
Дүн		1	-	1	-		
Бусад хууль тогтоомжтой холбоотой							
1	Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн Х/1225 дугаар албан бичгийн дагуу Шүүхийн Сахилгын хороо нь Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Монгол Улсын Дээд шүүхийн D блок-д байрлан үйл ажиллагаа явуулж, халаалтын цогц системийн засварын ажлыг 2023 оноос хойш хийсэн боловч тус хорооны нэр дээр газар эзэмших эрхийн гэрчилгээг аваагүй байна.	1	-			1	-
2	Төсвийн шууд захирагчийн бүрэн эрхийн хүрээнд санхүүгийн тайланг төрийн аудитын байгууллагад хуульд заасан цаглаварт хугацаанд ирүүлдэггүй байна.	1	-			1	-
3	Худалдан авах ажиллагааны 2024 оны төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газраас баталсан босго үнийг баримтлаагүй, сонгон шалгаруулах хэлбэрийг босго үнийн дагуу төлөвлөж, батлаагүй байна.	1	-			1	-
4	Тендерийн бичиг баримтын боловсруулалттай холбоотой дараах зөрчил байна. 1.Тээвэр шатахуун, ШСХ/20240202011 тендер шалгаруулалтын үнэлгээний хүснэгтэд тендер оролцогч Шунхлайтрейдинг ХХК, Петростар ХХК-уудын 2021-2023 оны борлуулалтын орлогуудыг ижил дүнгүүдээр тусган оруулсан байна. 2.Ерөнхий гэрээгээр худалдан авсан ШСХ/001 захиалгын дугаартай 9 ширхэг принтерийн худалдан авалтыг архивын нэгж үүсгэж, хадгалаагүй байна.	1	-			1	-
5	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2022 онд батлан мөрдөж байгаа бөгөөд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.	1	-			1	-
Дүн		5	-			5	-
НИЙТ		6	-	1	-	5	-